


ЗӨВШӨӨРСӨН:
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ӨРДЭМБИЛЭГ

Ц. Өрдэмбилэг



БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА М. НАРАНПҮРЭВ



ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН
“ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ” ҮНДСЭН
МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r) 09120

ХУГАЦАА: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2022 он

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ:

- М.Наранпүрэв Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Монгол Японы эмнэлгийн Эмнэл зүй эрхэлсэн орлогч захирал, Аангаах ухааны доктор, зөвлөх зэргийн эмч
- Б.Цолмон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичиг, Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, Интермед эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
- Ц.Ганбат Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн зөвлөх эмч, Анагаах ухааны магистр, зөвлөх зэргийн эмч
- Ш.Энх-Амгалан Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
- Д.Пүрэвдорж Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
- Ц.Ундрам Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрчимт эмчилгээний тасгийн эмч, Анагаах ухааны магистр, ахлах зэргийн эмч
- Х.Чулуунчимэг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч , Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Эрүүл мэндийн яамны Эрчимт эмчилгээний мэргэжлийн салбар зөвлөл
Эрүүл мэндийн хөгжлийн төв
Монголын эрчимт эмчилгээний нийгэмлэг
Улсын нэгдүгээр төв эмнэлэг
Улсын гуравдугаар төв эмнэлэг
Улсын хоёрдугаар төв эмнэлэг
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
Гэмтэл согог судлалын үндэсний Төв

ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын
дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

Б.Туяа

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын
мэргэжилтэн

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
11 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөгжил дэвшил, хүнд өвчтөний эрчимт эмчилгээний хэрэгцээ шаардлагатай холбоотойгоор нарийн мэргэжлийн эрчимт эмчилгээний эмчийн мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх тусгай сургалт нэн шаардлагатай болж байна.

1950-иад онд Европын орнуудад полимиелитын цар тахал дэлгэрч олон зуун өвчтөн амьсгалын дутагдлаар нас барах аюул тулгарсан үед өвчтөнүүдийг тусгай тасагт хэвтүүлж зохиомол амьсгал хийж байсан. 1960-аад оны эхэн үеэр мэс заслын тусламж хөгжих үед өвчтөнг хянах, амин үзүүлэлтүүдийг хэвийн хэмжээнд тогтворжуулж эмчлэх тусгайлан бэлтгэсэн өрөө, тасалгааны хэрэгцээ гарч хүнд өвчтөн эмчилдэг эрчимт эмчилгээний тасаг бий болсон. Улмаар дэлхий даяар эмнэлгийн тусламжийн хөгжлийг даган зүрхний, уушгины, мэдрэлийн, хүүхдийн, нярайн эрчимт эмчилгээний тасгууд үүсэн хөгжсөн байна.

Тухайн орны анагаах ухааны хөгжил, эмнэлгийн тусламж үйлчилгээний уламжлалаас хамааран эрчимт эмчилгээний тасгууд нээлттэй болон хаалттай хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Манай улсын эрчимт эмчилгээний тасгууд хаалттай хэлбэрээр ажилладаг. Хаалттай хэлбэрийн үед эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлж байгаа өвчтөнийг зөвхөн эрчимт эмчилгээний тасгийн эмч хариуцаж эмчилдэг. Нээлттэй хэлбэр нь мэс заслын болон дотор, мэдрэлийн эмч нар өвчтөнөө хүндэрч эрчимт эмчилгээний тасагт шилжсэн, хэвтсэн үед өөрөө хариуцаж эмчилдэг. Нээлттэй хэлбэр нь АНУ, Тайван, БНСУ, Япон зэрэг орнуудад давамгайл байдаг бол хаалттай хэлбэр нь Европын орнууд, ОХУ-д хөгжсөн байдаг. Сүүлийн үеийн судалгаанд хаалттай хэлбэрийн эмчилгээний үр дүн илүү гарсан байдаг.

Эрчимт эмчилгээний шинжлэх ухаан нь эрүүл мэндийн амь тэнссэн үеийн тусламжийн чиглэлээр дагнасан анагаах ухааны нэгэн салбар ухаан (discipline), бас тусгайлсан нэгэн нарийн мэргэжил (specialty) мөн. Амь тэнссэн үеийн анагаах ухааны чухал хэсэг болох эрчимт эмчилгээний тусламжийг сайжруулах, олон улсын эмнэлгийн тусламжийн чиг хандлагын дагуу эрчимт эмчилгээний тусламжийг чанартай үзүүлэх хүний нөөцийг бэлдэх зорилгоор “Эрчимт эмчилгээний эмчийн үндсэн мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр”- ийг боловсруулсан болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Амь тэнссэн төлөвт орсон эмчлүүлэгчид эрчимт эмчилгээний тусламжийг эмнэлгийн шатлалын аль ч түвшинд нотолгоонд тулгуурлан үзүүлэх цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэх.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Биеийн байдал нэн хүнд төлөвт шилжсэн хийгээд хүндрэх эрсдэлтэй эмчлүүлэгчийг эрт таних болон эрчимт эмчилгээний тусламжийг нотолгоонд суурилсан зарчмаар үзүүлж хүн амын эрүүл мэнд, амь насыг авран хамгаалах үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; амь тэнссэн эмчлүүлэгчид эхний зүгшрүүлэх тусламжийг цаг хугацаанд нь үзүүлж өвчний оношилгоо, шалтгааны эсрэг болон эрхтэн дэмжих, орлуулах эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; өвчтөнд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрчимт эмчилгээний тусламжийг үр дүнтэй үзүүлж чаддаг эмч байна.

ДӨРӨВ. “ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМЧ”-ИЙН ЦӨМ ЧАДАМЖ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Эрчимт эмчилгээний эмч (*Intensivist*)
2. Мэргэжлийн байх (*Professionalism*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийн эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Эрчимт эмчилгээний эмч (*Intensivist*):
 - Амь тэнссэн төлөвт буй эмчлүүлэгчид чухлын дарааллыг баримтлан үндсэн үнэлгээ хийж, зүгшрүүлэх тусламж (*Basic assessment and support*)-ийг үзүүлэх;
 - Өвчтөнд эхний зүгшрүүлэх тусламжийг үзүүлэх явцдаа лавшруулсан үнэлгээг хийх, өөрөөс болон ар гэрээс асуумж авах (*SAMPLE* болон *дэлгэрэнгүй асуумж*);
 - Өвчтөний нийгмийн гарал угсаа, шашин шүтлэг, арьс өнгө үл харгалзан эрчимт эмчилгээний тусламжийг үзүүлэх үүргээ ухамсарлан ажиллах;
 - Эмнэлгийн шатлалын аль ч түвшинд хийгдэх эрчимт эмчилгээний үндсэн оношилгоо, эмчилгээний гарлан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх, тэдгээртэй холбоотой осол хүндрэлүүд, авах арга хэмжээг онол, дадлагын хүрээнд хамран суралцаж эзэмших;
 - Эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж, хяналтын хэрэгслүүдийг удирдах, гарааны болон явцын тохиргоог зөв хийх, алдааны дохиоллын шалтгааныг тогтоох, арилгах, хяналтын хэмжүүрийг зөв шинжлэн таних;
 - Өвчтөний хувийн нууцыг хадгалах;

- Өвчтөний өвдөлт, оюун ухааны байдлын өөрчлөлт жижиг шинж тэмдгүүдийг ч бүгдийг харгалзан тусламжийг нягт нямбай үзүүлэх;
 - Нөөц хязгаарлагдмал нөхцөлд бололцоонд тулгуурлан эрчимт эмчилгээний үнэлгээ, тусламжийн орлуулах, тооцоолох, үнэлэх аргаар хийж дадах;
 - Эрүүл мэндийн бүртгэл болон тайлан, өвчний түүхийн маягтыг зохих журмын дагуу, цаг хугацаанд нь хөтлөх;
2. Мэргэжлийн байх (Professionalism):
- Эрүүл мэндийн болон бусад хууль тогтоолд заасан эмчийн ёс зүйн хэм хэмжээ мэргэжлийн зөв хандлага, зан төлөвийн төлөвшилтийг эзэмшинэ;
 - Цаг баримталж, эмнэлгийн дүрэм горимд нийцсэн хувцаслалттай байх;
 - Өвчтөнийг хувь хүний хувьд хундэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
 - Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн асран хамгаалагч, төрөл, садны хунтэй хундэтгэлтэй харилцах;
 - Орон нутагт өөрийн мэргэшлээр ажиллах, хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
 - Эмнэл зүйн шийдвэрийг түргэн шуурхай гаргаж амь тэнссэн эмчлүүлэгчийг эмчлэх арга барилыг эзэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг суралцах хугацаанд зохион байгуулах;
 - Үй олноор гэмтсэн, байгалийн гамшиг, онц халдварт өвчин эмгэг тархсан онцгой үед ажиллаж чадах ур чадвар;
3. Суралцагч (Learner):
- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад хамрагдах;
 - Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшилтэй хөл нийлүүлэн бие даан тасралтгүйгээр суралцах, нотолгоотой мэдээллийн эх үүсвэрийг судлах, дун шинжилгээ хийх;
 - Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд өөрийн эзэмшсэн туршлагаас хуваалцах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах;
4. Харилцагч (Communicator):
- Суралцагч нь хүнд өвчтөн түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хунтэй харилцах, хүндлэх хайрлах ёс зүйтэй харилцах;
 - Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах;
 - Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх;
5. Хамтрагч (Collaborator):
- Эмч-өвчтөн, эмч-эмнэлгийн ажилтантай харьцах харьцааны ур чадвар хандлагыг эзэмшин багаар ажиллах;

- Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах;
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):
- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
 - Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader):
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
 - Эмнэлэг, эрчимт эмчилгээний тасагт тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил:

- Сургалтад эмчилгээний мэргэжлээр суралцаж буй резидент эмч нар дотрын эмгэгийн эрчимт эмчилгээ, мэс заслын эмгэгийн эрчимт эмчилгээ, гэмтэл, эх барих, эмэгтэйчүүд судлал, яаралтай тусламж судлал, гемодиализ болон мэдээгүйжүүлэг гэсэн чиглэлээр тойрогт заавал хийж сонгон суралцах чиглэлээр сургалтад хамрагдана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс “Эрчимт эмчилгээ судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага энэхүү сургалтын үндсэн байгууллага байна.
- Хэрэв сургалт явуулах хангалттай орчин бүрдээгүй тохиолдолд бусад эрүүл мэндийн байгууллагыг оролцуулан сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтарч ажиллана.
- “Эрчимт эмчилгээ судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээнд нэгдсэн бусад байгууллага)-ын эрчимт эмчилгээний тасаг, яаралтай тусламжийн тасаг, хагалгааны өрөө, гемодиализын өрөө, хурлын танхим, сургалтын анги танхимд сургалт явагдана.
- Эрчимт эмчилгээ судлалын үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй бүх резидент эмч нар эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, халдварын сэргийлэлт, хяналт, амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний

нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад (orientation) заавал хамрагдсан байна.

6.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд эмнэлгийн аль ч шатлалд ганцаар бие даан тусламж, үйлчилгээ узуулж чадах тувшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амь тэнссэн өвчтөний эхний зүгшрүүлэх тусламж, оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гуйцэтгэж, туршлага хуримтлуулна.

6.2.1 Яаралтай тусламж (emergency care) (аль ч тойролтод тохиолдох):

Амь тэнссэн өвчтөнд үндсэн үнэлгээ хийж эхний зүгшрүүлэх тусламжийг чухлын дарааллыг баримтлан үзүүлж чаддаг болох:

1. Амьсгаадах үед үзүүлэх яаралтай тусламж
2. Цээжээр гэнэт өвдөх үед авах арга хэмжээ
3. Зүрхний цахилгаан бичлэгийн түргэвчилсэн үнэлгээ
4. Амьнд осолтой хэм алдагдлын үед авах арга хэмжээ
5. Хэвлийгээр хүчтэй өвдөх үед авах арга хэмжээ
6. Амьсгалын хурц дутмагшил, хэлбэр авах арга хэмжээ
7. Зүрх судасны хурц дутмагшил, хэлбэр, авах арга хэмжээ
8. Шоктой өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж:
9. Дотрын өвчнүүдийн үеийн яаралтай тусламж, ялган оношилгоо
10. Дотоод шүүрлийн эрхтний дутмагшил, хэлбэр, авах арга хэмжээ
11. Мэс заслын цочмог өвчнүүдийн яаралтай тусламж:
 - Хөндийт эрхтэн цоорох өвчнүүд
 - Мухар олгойн хурц үрэвсэл
 - Нойр булчирхайн хурц үрэвсэл
 - Цөсний хүүдийн хурц үрэвсэл
 - Гэдэсний түгжрэл
12. Цочмог цус алдалтын үед үзүүлэх яаралтай тусламж:
 - Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж
 - Хоол боловсруулах замын цус алдалтын яаралтай тусламж
 - Гэмтлийн цус алдалтын яаралтай тусламж
 - Урт мөчдийн цус алдалтыг тогтоох
13. Гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж:
 - Гэмтэлтэй өвчтөнийг үнэлэх
 - Цээжний гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж
 - Хэвлийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж
 - Нугасны гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж
 - Тархины гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж
 - Мөчдийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж
 - Хэвлийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх тусламж

- Хүзүү болон нуруу нугасны гэмтэлтэй өвчтөнд бэхэлгээ хийх болон тээвэрлэх

14. Хүрээлэн байгаа орчны нөлөөт эмгэгүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж:

- Хордлогын үед үзүүлэх яаралтай тусламж
- Дулаанд цохиулах үед үзүүлэх яаралтай тусламж
- Цахилгаан, туяанд цохиулах үед үзүүлэх яаралтай тусламж
- Усанд живсэн хүнд үзүүлэх яаралтай тусламж
- Түлэгдлийн үед үзүүлэх яаралтай тусламж
- Осголтын үед үзүүлэх яаралтай тусламж
- Хөлдөлтийн үед үзүүлэх яаралтай тусламж

6.2.2 Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин (тойролт тус бүрээр):

1. Өвчин тус бүрийг оношилж, эмчлэх, тусламж узуулж чаддаг болох
2. Тусламж, уйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тасгаас ЭЭТ-т өвчтөн шилжүүлэх заалтыг мэддэг болох;
3. Дээд шатлалын эмнэлэгт өвчтөнг аюулгүйгээр шилжүүлэх аргад суралцах
4. Нэн хүн өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнд онош болон үзүүлж буй тусламжийг зөв тайлбарлах, өвчнийг эрт үед нь илрүүлэх талаар зааж, зөвлөгөө өгөхөд суралцах.

Дотрын эмгэгийн эрчимт эмчилгээний өвчнүүд:

№	Онош	Diagnosis	ICD 10 Code
1	Чихрийн шижин, түүний хүндрэлүүд	Diabetes mellitus, with complications	E 11
2	Гипертонийн криз	Hypertensive emergencies	I10
3	Уушгины хатгаа, олон шалтгаант. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэл	Pneumonia, Acute exacerbation of COPD	J18, J69, J85, J84,
4	Элэгний хатуурал, элэгний цочмог дутагдал	Cirrhosis of liver, acute liver failure	K70-K74,
5	Тархины цус хомсдолын харвалт, тархины цус харвалт	Ischemic stroke, Cerebral hemorrhage	I60-I69
6	Зүрхний шигдээс, зүрхний дутагдал	Acute myocardial infarction,	I21-I24, I50
7	Зүрхний гаралтай шок	Cardiogenic shock	R57
8	Зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдал	Life threatening arrhythmia	I44-I45
9	Зүрх чихэлдэх	Cardiac tamponade	I31.4
10	Зүрхний хавхлагын төрөлхийн гажиг, хүндрэлүүд	Cardiac valvular diseases, complications	I05-I09
11	Шингэн алдалтын шок	Hypovolemic shock	R57.1

12	Харшлын шок	Anaphylactic shock	T78.2
13	Уушгины артерийн бөглөрөл, бөглөрлийн шок	Pulmonary artery embolism, Obstructive shock	I26-I27
14	Гуурсан хоолойн аминд аюултай багтраа	Asthma, acute exacerbation	J45
15	Амьсгалын дутагдал	Respiratory failure	J96
16	Уушгины артерийн даралт ихсэлт	Pulmonary hypertension	I27
17	Булчин сулрах эмгэгүүд	Diseases of myoneural junction and muscle	J70-J73
18	Энцефалит, хүндрэлүүд	Encephalitis, complications	G00-G09
19	Энцефалопати	Encephalopathy	G93.40
20	Менингит	Meningitis	G00-G03
21	Тархины үхэл	Brain death	G93.82
22	Бөөрний цочмог дутагдал	Acute kidney failure	N17.9
23	Бөөрний архаг дутагдал	Chronic kidney failure	N18.9
24	Чихрийн шижингийн цочмог хүндрэлүүд	Acute complications of diabetes mellitus	E11.8
25	Бөөрний дээд булчирхайн цочмог дутагдал	Adrenal insufficiency	E27.9
26	Бамбайн хордлого	Thyrotoxicosis	E05.90
27	Бамбайн дутагдал	Thyroid insufficiency	E07.9
28	Эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой халдвар	Nosocomial infection	Y95
29	Үжил, үжлийн шок	Sepsis, septic shock	A41
30	Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар	Multidrug resistance bacterial infection	Z16.35
31	Мөөгөнцрийн халдвар, үжил	Fungal infection, sepsis	B37.9
32	Вирусын халдвар, үжил	Viral infection, sepsis	B34
33	Судсанд түгмэл бүлэгнэх хам шинж	Disseminated intravascular coagulation	D65
34	Цусны хавдарын хүндрэл	Malignant neoplasm of lymphoid, hematopoietic and related tissue	C96.9
35	Элэгний цочмог үрэвсэл	Acute hepatitis	B17.9, K75.9
36	Элэгний хатуурлын хүндрэлүүд	Cirrhosis of liver, complications	K70-K77
37	Элэгний дутагдал, элэг бөөрний хам шинж	Acute hepatic failure, hepatorenal syndrome	K72.00, K76.7
38	Ходоод гэдэсний замын цус алдалт	Gastrointestinal hemorrhage	K92.2
39	Нойр булчирхайн цочмог үрэвсэл	Acute pancreatitis	K85

Мэс заслын болон гэмтлийн эмгэгийн эрчимт эмчилгээний өвчнүүд:

№	Онош	Diagnosis	ICD 10 Code
1	Зүрхний мэс заслын дараах эрчимт эмчилгээ	Post cardiac surgery care	Z48.812
2	Пневмоторакс болон Баротравмын хүндрэл	Pneumothorax and barotrauma	J93
3	Хүнд хэлбэрийн уушгины цус алдалт	Pulmonary hemorrhage	R04.84
4	Тархины гэмтэл	Head trauma	S09
5	Цээжний гэмтэл	Chest trauma	S20
6	Хүнд хэлбэрийн хавсарсан гэмтэл	Multi trauma	T07
7	Түлэгдэлтийн үеийн шингэн сэлбэлт	Burns and corrosions	T20-32
8	Осголт, хөлдөлтийн үеийн шингэн сэлбэлт	Superficial frostbite	T33-35
9	Хэвлийн хөндийн мэс заслын дараах эрчимт эмчилгээ	Other operations on abdominal region	54
10	Хөндийт эрхтэний цооролт, гялтантас	Peritonitis, unspecified	K65.9
11	Зүрхний мэс ажилбарын дараах эрчимт эмчилгээний тусламж	Other postprocedural cardiac functional disturbances.	I97.1
12	Пневмоторакс болон Баротравмын хүндрэл, оношилгоо, авах арга хэмжээ	Pneumothorax	J93.9
13	Хүнд хэлбэрийн уушгины цус алдалт	Hemorrhage from other sites in respiratory passages	R04.899
14	Тархины гэмтлийн эрчимт эмчилгээ	Injuries to the head ICU	S00-09
15	Цээжний гэмтлийн эрчимт эмчилгээ	Superficial injury of thorax ICU	S20-29
16	Хүнд хэлбэрийн хавсарсан гэмтлийн эрчимт эмчилгээ	Multi trauma ICU	T00-T07
17	Түлэгдэлтийн үеийн шингэн сэлбэлт	Burns and corrosions	T20-32
18	Осголт, хөлдөлтийн үеийн шингэн сэлбэлт, өвдөлт намдаалт	Superficial frostbite	T33-35
19	Их хэмжээний цус сэлбэлт хийх аргачлал	Other transfusion of whole blood	99.03
20	Хэвлийн хөндийн мэс заслын дараах эрчимт эмчилгээ	Other operations on abdominal region	54
21	Хөндийт эрхтэний цооролт,	Peritonitis, unspecified	K65.9

хэвлийн гялтантас, арга хэмжээ

Эх барих эмэгтэйчүүдийн эрчимт эмчилгээний өвчнүүд

№	Онош	Diagnosis	ICD 10 Code
1	Артерийн даралт ихсэлт ба жирэмсэн	Unspecified maternal hypertension.	O16
2	Манас таталтын урьдлын хүнд хэлбэр	Severe pre-eclampsia	O14.1
3	Артерийн даралт ихсэлт ба жирэмсэн	Unspecified maternal hypertension.	O16
4	Манас таталтын урьдлын хүнд хэлбэр	Severe pre-eclampsia	O14.1
5	Манас таталт, манас таталтын урьдлын хүнд хэлбэр	Severe pre-eclampsia	O14.1
6	Цусны эргэлтийн алдагдалтай эхийн эрчимт эмчилгээ	Diseases of the circulatory system complicating pregnancy, childbirth and the puerperium.	O99. 4
7	Зүрхний дутагдалтай эхийн эрчимт эмчилгээ	Diseases of the circulatory system complicating pregnancy, unspecified trimester.	O99. 419, I50.9
8	Аминд осолтой зүрхний хэм алдагдлын эрчимт эмчилгээ	Heart Failure, Unspecified Diseases of the circulatory system complicating pregnancy, unspecified trimester.	O99. 419, I49.9
9	Элэгний хатуурлын ээнэгшил алдагдалтай эхийн эрчимт эмчилгээ	Cardiac arrhythmia, unspecified Liver and biliary tract disorders in pregnancy, childbirth and the puerperium.	O26.6
10	Элэгний дутагдалтай эхийн эрчимт эмчилгээ	Hepatic failure, not elsewhere classified	K72
11	Хүнд хэлбэрийн цөс зогсонгшилтой эхийн эрчимт эмчилгээ	Liver and biliary tract disorders in pregnancy, unspecified trimester.	O26.619
12	Хүнд хэлбэрийн ялтас эсийн цөөрөлтэй эхийн эрчимт эмчилгээ	Abnormal hematological finding on antenatal screening of mother	O28.0, D69.6
13	Уушгины хурц хатгаатай эхийн эрчимт эмчилгээ	Thrombocytopenia, unspecified Pneumonia, organism unspecified.	J18, O99.5
14	Бөөрний дутагдалтай эхийн эрчимт эмчилгээ	Unspecified kidney failure	N19
15	Бамбайн хордлогын хүнд хэлбэр, кардиомиопатитай	Thyrotoxicosis (hyperthyroidism) Cardiomyopathy in diseases	E05, I43.8

16	эхийн эрчимт эмчилгээ Уушгины артерийн бүлэнт бөглөрөлтэй үеийн эрчимт эмчилгээ. Доод мөчдийн вений бүлэнт бөглөрөл.	classified elsewhere Venous complications and hemorrhoids in pregnancy.	O22
17	Чихрийн шижингийн декомпенсацтай гипо- гипергликемитэй эхийн эрчимт эмчилгээ	Diabetes mellitus in pregnancy, childbirth, and the puerperium Hypoglycemia, unspecified	O24, E16.2
18	Энцефалопатитай эхийн эрчимт эмчилгээ	Diseases of the nervous system complicating the puerperium Encephalopathy, unspecified	O99.355, G93.40
19	Эрхтэн суулгалт ба жирэмсэн	Transplant	00.91- 00.93
20	Антифосфолипид хамшинж	Antiphospholipid syndrome	D68.61
21	СТБ хамшинж	Disseminated intravascular coagulation [defibrination syndrome]	D65
22	Эх барихын шалтгаант үжил	Puerperal sepsis	O85
23	Кесар хагалгааны дараах перитонит	Diseases of the digestive system complicating pregnancy, childbirth and the puerperium Peritonitis	O99.6, K65
24	Амилуулалтын дараах тусламж	Cardiac arrest with successful resuscitation	I46.0
27	Эх барих эмэгтэйчүүдэд тохиолдох шокийн үед авах арга хэмжээ	Shock during or following labor and delivery	O75.1
28	Эх барихын шалтгаант бөөрний цочмог дутагдал. Гемодиализ	Postpartum acute kidney failure Dependence on renal dialysis	O90.4, Z99.2
29	Уушгины цочмог хаван	Pulmonary edema	J81
30	Амьсгалын дистресс хамшинж	Acute respiratory distress syndrome	J80
31	HELLP хамшинж	HELLP syndrome	O14.2
32	Эх барихын цочмог цус алдалт	Other intrapartum hemorrhage	O67.8
33	Эх барихын үжил, үжлийн шок	Puerperal sepsis	O85
34	Ураг орчмын шингэний бөглөрөл	Amniotic fluid embolism in pregnancy, first trimester.	O88.111
35	Бамбайн криз	Thyrotoxicosis, unspecified with thyrotoxic crisis or storm	E05.91
36	Кетоацидоз, гипогликеми	Type 2 diabetes mellitus with ketoacidosis	E11.1
37	Цус, цусан бүтээгдхүүн сэлбэлтийн хүндрэлийн үед	Complications following infusion, transfusion or therapeutic	T.80

	авах арга хэмжээ	injection.	
38	Ухаангүй байдлын ялган оношилгоо	Coma	R40. 2
39	Харшлын шок	Anaphylactic shock, unspecified	T78. 2
40	Манас таталт	Eclampsia	O15

6.2.3 Гардан үйлдлийн жагсаалт

1	Хүнд өвчтөн үзэх, хянах,эмчлэх	Interview, evaluation, consultation, and examination	89
2	Хүнд өвчтөний амин үзүүлэлтүүдийн хяналт хийх	Circulatory Monitoring	89.6
3	Амьсгалын зам чөлөөлөх		
4	Интубацийн гуурсаар соруулах	Other lavage of bronchus and trachea	96.56
5	Зохиомол амьсгалын аппаратыг тохируулах	Other continuous mechanical ventilation	96.7
6	Хүнд өвчтөн үзэх, хянах,эмчлэх	Interview, evaluation, consultation, and examination	89
7	Хүнд өвчтөний амин үзүүлэлтүүдийн хяналт хийх	Circulatory Monitoring	89.6
8	Венийн судсан уян зүү тавих	Peripheral venous catheter	996.62
9	Интубацийн гуурсаар цэр салст соруулах	Other lavage of bronchus and trachea	96.56
10	Давсганд гуурс байрлуулах	Insertion of indwelling urinary catheter	57.94
11	Ходоодны зонд тавих	Other gastrostomy	43.19
12	Мэс заслын шархны боолт солих	Encounter for attention to dressings, sutures and drains	Z48.0
13	Хүнд өвчтөн эмнэлэг доторх тээвэрлэлт	Intra-hospital transportation of critically ill patients	
14	Цусны шинжилгээнд үнэлгээ хийх		
15	Цусны хийжилтийн шинжилгээнд үнэлгээ хийх	Measurement of systemic arterial blood gases	89.65
16	Дүрс оношилгооны шинжилгээнд үнэлгээ хийх	Diagnostic Radiology	87
17	Амилуулах суурь тусламж үзүүлэх	Cardiopulmonary resuscitation, not otherwise specified.	99.60

18	Амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх	Cardiopulmonary resuscitation, not otherwise specified.	99.60
19	Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих	Insertion of endotracheal tube	96.04
20	Артерийн гуурс тавих	Arterial catheterization	38.91
21	Артер хатгаж цусны хийжилтийн шинжилгээ хийх	Measurement of systemic arterial blood gases	89.65
22	Төв венийн гуурс байрлуулах (v.Femoralis)	Central venous catheter placement with guidance	38.97
23	Төв венийн гуурс байрлуулах(v.jugularis externa)	Central venous catheter placement with guidance	38.97
24	Төв венийн гуурс байрлуулах(v.subclavia)	Central venous catheter placement with guidance	38.97
25	Дефибрилятороор цохиулах	Other electric countershock of heart	99.62
26	Шоктой өвчтөнийг хүлээж авч сэхээх арга хэмжээ авах	Shock, unspecified	R57.9
27	Ухаангүй өвчтөнийг хүлээж авч арга хэмжээ авах	Coma	R40. 2
28	Зохиомол амьсгалд өвчтөнийг оруулан удирдах	Continuous mechanical ventilation of unspecified duration	96.70
29	Артерийн даралтыг цустай аргаар хянах	Systemic arterial pressure monitoring.	89.61
30	Төв венийн даралтыг монитороор хянах	Central venous pressure monitoring	89.62
31	Зүрхний хэм алдаглын эмчилгээг хийж хянах	Cardiac dysrhythmia, unspecified.	427.9
32	Зүрхний цахилгаан бичлэгийн түргэвчилсэн аргаар үнэлэх	Electrocardiogram	89.52
33	Зүрхний дутагдлын эмчилгээг хийх	Heart failure	I50
34	Бүлэн хайлуулах эмчилгээ хийх	Injection or infusion of thrombolytic agent.	99.10
35	Орны дэргэдэх зүрхний Эхогоор цус эргэлт хянах	Diagnostic ultrasound of heart	88.72
36	Кардиоверси хийх	Atrial cardioversion	99.61
37	ARDS-тэй өвчтөнд зохиомол амьсгал удирдах	Acute respiratory distress syndrome Dependence on respirator	J80+Z99.1
38	Цусны хийжилтийн	Measurement of systemic	89.65

	шинжилгээнд үнэлгээ хийх	arterial blood gases	
39	Цээжний хөндийд хатгалт хийж гуурс байрлуулах	Thoracentesis	34.91
40	Уушигны дүрс оношилгооны үнэлгээг хийх	Diagnostic of ultrasound of other sites of thorax	88.73
41	Орны дэргэдэх уушигны ЭХО хийх	Diagnostic of ultrasound of other sites of thorax	88.73
42	Амьсгалын цочмог дутагдалтай өвчтөнд эмчилгээ, оношилгоо хийх	Acute and chronic respiratory failure	J96.2
43	Гемодиализын Төв венийн гуурс байрлуулах	Venous catheterization for renal dialysis	38.95
44	Бөөрний цочмог дутагдлын үед гемодиализ эмчилгээ хийх	Encounter for care involving renal dialysis	Z49
45	Бөөрний архаг дутагдлын цочмог хүндрэлийн үеийн бөөр орлуулах эмчилгээг хийх	Dependence on renal dialysis	Z99. 2
46	Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээ хийх	Encounter for adequacy testing for hemodialysis	Z49.31
47	Чихрийн шижингийн хүндрэлийн үеийн эмчилгээг хийх	Type 2 diabetes mellitus with unspecified complications	E11.8
48	Тархины харвалттай өвчтөний оношилгоо эмчилгээ	Nontraumatic intracranial hemorrhage, unspecified	I62.9
49	Гавлын дотоод даралтын хяналт хийх	Intracranial pressure monitoring	01.10
50	Тархины дүрс оношилгооны шинжилгээг үнэлэх	Abnormal brain scan	R94.02
51	Нугасны хатгалт хийж шинжлэх	Spinal tap	03.31
52	Захын мэдрэл, булчингийн эмгэгтэй өвчтөнд эрчимт эмчилгээний тусламж үзүүлэх	Nerve, nerve root and plexus disorders	G50-59
53	Үжлээс аврах аяны 3 цагийн багцийг хэрэгжүүлэх		
54	Үжлээс аврах аяны 6 цагийн багцийг хэрэгжүүлэх		
55	Үжлийн шоктой өвчтөнд эхний сэхээх арга хэмжээ авах	Severe sepsis with septic shock	R65.21
56	Микробиологийн шинжилгээг үнэлэх		
57	Хоол боловсруулах дээд замаар цус алдалтыг эмчлэх	Gastrointestinal haemorrhage, unspecified	K92. 2

58	Блейкморийн зонд тавих	Insertion of sengstaken tube	96.06
59	Эрчимт эмчилгээний өвчтөнд шим тэжээлийн тооцоо хийж хооллох	Dietary counseling and surveillance	Z71.3
60	Элэгний дутагдлын эмчилгээг хийх	Hepatic failure, not elsewhere classified	K72
61	Хэвлийд хатгалт хийж гуурс байрлуулах	Percutaneous abdominal drainage	54.91
62	Орны дэргэд хэвлийн Эхо хяналт хийх	Diagnostic ultrasound	88.7
63	Хэвлийн шингэний шинжилгээг үнэлэх	Ascites	R18
64	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх	Transfusion of packed cells.	99.04
65	Цус бүлэгнэлтийн шинжилгээг үнэлэх		
66	Эх барихын шалтгаантай их хэмжээний цус алдалтын үед арга хэмжээ авах	Other intrapartum hemorrhage	O67.8
67	Ерөнхий мэдээгүйжүүлэг хийх	Other complications of anesthesia	T88.5
68	Орчны мэдээгүйжүүлэг хийх	Local anesthetics	Y48.3
69	Ажилбарын үеийн тайвшруулалт хийх	Anesthesia for upper gastrointestinal endoscopic procedures, endoscope introduced proximal to duodenum; not otherwise specified	00731
70	Хүүхдийн амьсгалын зам чөлөөлж интубаци хийх		
71	Хүүхдэд зохиомол амьсгал удирдах	Continuous mechanical ventilation of unspecified duration	96.70
72	Хүүхдэд шингэн сэлбэх		
73	Хүүхдэд эмийн тун тооцох		
74	Хүүхдэд ясанд хатгалт хийх	Insertion of Infusion Device into Bone Marrow, Percutaneous Approach	07HT33Z
75	Хүүхдийн амилуулах тусламж үзүүлэх		
76	Их хэмжээний цус сэлбэлт хийх	Other transfusion of whole blood	99.03
77	Уушигны гэмтэлтэй өвчтөнд зохиомол амьсгал удирдах	Continuous mechanical ventilation of unspecified	96.70

78	Тархины гэмтэлтэй өвчтөнд зохиомол амьсгал удирдах	duration Continuous mechanical ventilation of unspecified duration	96.70
79	Хүнд өвчтөний тээвэрлэлтийг эмнэлэг хооронд хийх	Transportation of critical patients between hospitals	

Загвар 1

6.3. Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)

№	Сургалтын хэлбэр	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэх үүн	Удирдагч, хамтрагч
1	Эмч нарын тойрон үзлэг	Бүх суралцагчид	15мин/өвчтөн 7 хоногт 5 удаа	Эрчимт эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч нар
2	Хүнд өвчтөний сургалтын тойрон үзлэг, өвчний түүх хөтлөх	Бүх суралцагчид	1 цаг/өвчтөн 7 хоногт 5 удаа	Эрчимт эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч нар
3	Оношийн үндэслэл, өдөр тутмын эмчилгээний төлөвлөгөө бичих	Бүх суралцагчид	1 цаг. 7 хоногт 5 удаа	Эрчимт эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч нар
4	Гардан хийх үйлдэл	Бүх суралцагчид	1 цаг. 7 хоногт 3 удаа	Эрчимт эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
5	Лаборатори болон радиологийн шинжилгээний хариунд дүгнэлт хийх, эмнэлзүйтэй уялдсан шийдвэр гаргах	Бүх суралцагчид	2 цаг. 7 хоногт 5 удаа	Эрчимт эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
6	Ерөнхий мэдээгүйжүүлэгтэй мэс засалд оролцох	Өдөрт 1 суралцагч	1 цаг 7 хоногт 1 удаа	Хагалгааны хэсэг	Өвчтөн	Мэдээгүйжүүлгийн эмч, сувилагч

Хяналтын тойрон үзлэг: Суралцагч эмч хэвтэн эмчлүүлэхээр ирж байгаа өвчтөний биеийн байдлыг эмнэл зүйн сургагч багшид (бусад эмчид) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч бие даан эмчлүүлэгчтэй уулзаж асуумж цуглуулан, өвчний түүхтэй танилцаж, өвчтөний биеийн байдлыг үнэлж, урьдчилсан онош тавьж эмнэл зүйн сургагч багшид (бусад эмчид) танилцуулна.

Танилцуулгыг сургалтын өрөө гэх мэт өвчтөний өрөөнөөс өөр газар хийх бөгөөд хяналтын тойрон үзлэгээр өвчтнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг: Сургалтанд тохиромжтой 1 өвчтөн сонгож мэргэжлийн үзлэг шинжилгээ хийж урьдчилсан онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө гарган эмнэл зүйн сургагч багш болон хамтран суралцагч нарт танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэн байж болох хувилбаруудыг харилцан ярилцана.

Загвар 2

6.4. Танхимын сургалт (*On-the-Job Training*)

№	Аргачлал	Суралцаг чийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Хамтрагч
1	Бие даалт	1	Тохиромжтой цагт	Гэртээ, сургалтын танхим	Номын сан, интернет	Суралцагч, хамтран суралцагч
2	Лекц	10 хүртэл	7 хоногт 1 удаа 1-2 цаг	Сургалтын танхим	Танилцуулга (presentation)	Эмнэл зүйн сургагч багш
3	Журнал клуб буюу хэлэлцүүлэг	10 хүртэл	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, мэргэжлийн гадаад хэвлэлийн тойм	Суралцагч, Эмнэл зүйн сургагч багш
4	Симуляци, Дуураймал орчин	1-2 ээлжээр	2 цаг, 14 хоногт 1 удаа	Чамархай ясны лаборатори, сургалтын танхим	Чамархай яс	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3

6.5 Үйл ажиллагааны хуваарь

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08:20	Өвчтөн хүлээж авах тойрон үзлэг	Өвчтөн хүлээж авах тойрон үзлэг	Өвчтөн хүлээж авах тойрон үзлэг	Өвчтөн хүлээж авах тойрон үзлэг	Өвчтөн хүлээж авах тойрон үзлэг
09:00	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг,
10:00	Эмчилгээ оношилгооны ажилбар хийх	Эмчилгээ оношилгооны ажилбар хийх	Эмчилгээ оношилгооны ажилбар хийх	Эмчилгээ оношилгооны ажилбар хийх	Эмчилгээ оношилгооны ажилбар хийх
12:00	Эмчлүүлэгчийн гэр бүлтэй уулзалт хийх	Эмчлүүлэгчийн гэр бүлтэй уулзалт хийх	Эмчлүүлэгчийн гэр бүлтэй уулзалт хийх	Эмчлүүлэгчийн гэр бүлтэй уулзалт хийх	Эмчлүүлэгчийн гэр бүлтэй уулзалт хийх
12:30	Өдрийн цайны цаг	Өдрийн цайны цаг	Өдрийн цайны цаг	Өдрийн цайны цаг	Өдрийн цайны цаг
13:30	Дүрс	Эмнэл зүйн	Эмнэл зүйн	Журнал клуб	Сувилахуйн

	оношилгооны тойрон үзлэг	сургалт	сургалт	сургалт	сургалт
14:30	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг	Орны дэргэдэх тойрон үзлэг
15:00	Давтан ажилбар, шинжилгээ	Давтан ажилбар, шинжилгээ	Давтан ажилбар, шинжилгээ	Давтан ажилбар, шинжилгээ	Давтан ажилбар, шинжилгээ
16:20	Эмчлүүлэгчийг хүлээлцэх тойрон үзлэг	Эмчлүүлэгчийг хүлээлцэх тойрон үзлэг	Эмчлүүлэгчийг хүлээлцэх тойрон үзлэг	Эмчлүүлэгчийг хүлээлцэх тойрон үзлэг	Эмчлүүлэгчийг хүлээлцэх тойрон үзлэг

ДОЛОО. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ЭРГЭХ ХОЛБОО

7.1. Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн ((*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга

- *Модульд суурилсан хичээл*: ММЭН ба ДМЭНН-ийн хамтран боловсруулсан мэдээгүйжүүлгийн ба эрчимт эмчилгээний модулиудийн дагуу нийгэмлэгийн гишүүд эмч нарын заах лекц, гардан сургалт, семинарын хичээлүүдэд оролцож, модуль тус бүрээр шалгалт өгөх
- *Семинар*: Баг бүлгээр хичээллэн эмнэлзүйн ховор тохиолдол, оношлох, эмчлэхэд түвэгтэй өвчин эмгэгүүдийг асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргаар бүх сонсогчдыг оролцуулахаар төлөвлөгдөнө. Энэ асуудлыг суралцагчид өөрсдөө зохион байгуулан хийхийн зэрэгцээ шаардлагатай гэж үзвэл багшийг урин оролцуулах бусад клиникийн эмч, резидентүүдийг урьж суулган ном хаялцах болон бусад сонирхолтой хэлбэрээр явуулах болно.
- *Зайлшгүй суралцах бие даалт*: Багш, тасгийн эрхлэгч, эмч нарын удирдлага дор өвчтөн үзэж, онош тогтоох лаборатори, рентген, дуран, хэт авиан болон

бусад шинжилгээний аргуудад өвчтөн бэлдэх, шинжилгээнд оролцох мэдээгүйжүүлэлтийн бэлтгэл хийх, эхний 6 сард мэдээгүйжүүлэлтэнд оролцож туслах, улмаар 6 сараас 1 жилийн хугацаанд багшийн хяналтын дор төлөвлөгөөт болон яаралтай хагалгаанд мэдээгүйжүүлэлтийг удирдан явуулах, эрчимт эмчилгээний тасагт хүнд өвчтөн үзэж эмчилгээ сувилгаанд биечлэн оролцох, сургалтын сүүлийн 6 сард бие даан мэдээгүйжүүлэлт хийх, нарийн мэргэжлийн эмнэлгүүдээр тойрон дадлага хийх зэрэг аргаар суралцана. Долоо хоногийн ажлын 40-өөс доошгүй цагт нь төлөвлөгдсөн сэдвийн дагуу бие даан эрэл хайгуул хийж унших, тэмдэглэх, бичих, судлах хэлбэрээр суралцан удирдагч багшдаа шалгуулан кредит биелүүлнэ.

- **Дадлага:** Эмнэлзүйн тойролтын дагуу бааз эмнэлгүүдэд мэдээгүйжүүлэгч, эрчимт эмчилгээний эмчийг дагалдан суралцахаас гадна эмчийн хяналтан доор бие даан ажилбаруудыг гүйцэтгэж, мэдээгүйжүүлгийг удирдана.

7.3.1 Төгсөлтийн шалгалт

“Эрчимт эмчилгээ судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын төгсөлтийн шалгалтыг эрх бүхий байгууллагуудын зохицуулалтын доор мэргэжлийн нийгэмлэг болон салбар зөвлөлийн хяналтанд өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд “Эрчимт эмчилгээний эмч”-ийн үнэмлэх олгоно.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*) 360 хэмийн үнэлгээ (*360 degree Assessment*):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professional), манлайлагч (leader) байх чадамжийг үнэлэхэд хэрэглэнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно.

Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

Mini-CEX /Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini – Clinical Evaluation Exercise):

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх 106 шинж тэмдгүүдээс 80%-аас доошгүй үйлдэл бүрд 3.-аас доошгүй удаа нийт 2 -аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct observation of procedural skills. DOPS)

Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 79 үйлдлээс 48- аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэл зүйн удирдагч багш нотолсон үнэлгээ. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment)

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэл зүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ. Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini –CEX, DOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалт эрхлэгч байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, сүлжээ эмнэлгийн төлөөлөл, сувिलाхуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.
- Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага доор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг эмнэлгийн сургалтын алба болон хариуцсан тэнхим, тасгаас хариуцан хэрэгжүүлэх бөгөөд жилийн эцэст суралцагчдийн зүгээс эмнэлзүйн сургагч багш болон хөтөлбөрт хаалттай болон нээлттэй асуултаас бүрдэх сургалтын агуулга бүрээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг асуумж судалгаагаар үнэлж шинэчлэх, сайжруулах хэсгийг олж тогтооно. Төгсөх дамжааны эмч ба ажил олгогчдын санал асуулгын үр дүн дээр үндэслэн хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг

шинэчлэн сайжруулах, тухайн хөтөлбөрөөр суралцагчийн эзэмших суралцахуйн үр дүн бүрийн хүрсэн түвшинг дээшлүүлэх үйл ажиллагааг явуулна.

- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.
- Хөтөлбөрт тусгагдсан тодорхой бус, ойлгомжгүй зүйлсийг Эрчимт эмчилгээний нийгэмлэгт хандан мэдээлэх, шийдвэрлүүлэх боломжтой.

Ерөнхий үнэлгээ:

№	Үнэлгээ хувиар	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний оноо(0-4)	Үнэлгээний болзол
1	90-100	A	4.0	Тухайн хичээлийн агуулгыг бүрэн бүтээлчээр ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдлэгээ чадварлаг ашиглаж чаддаг байх
2	80-89	B	3.0	Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдлэгээ үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх
3	70-79	C	2.0	Тухайн хичээлийн агуулгыг хангалттай хэмжээний ойлголт, авсан, холбогдох энгийн даалгаварыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлах бэлтгэлтэй болсон байх
4	60-69	D	1.0	Тухайн хичээлийн агуулгыг жигд ойлгоогүй харьцангуй хялбар ажилбаруудыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлахын тулд нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх шаардлагатай
5	0-59	F	0.0	Мэдлэг, чадвар, дадал хангалтгүй байх

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр он сар

Үнэлгээ хийгч: () эмнэл зүйн сургагч багш () сувилагч () бусад

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноо тавина уу.

Тухайн асуултанд үнэлгээ авах боломжгүй бол 0

Тухайн асуултыг 19% биелүүлсэн бол 1;

20-49% биелүүлсэн бол 2 ;

50-79 % биелүүлсэн бол 3;

80%-аас дээш биелүүлсэн бол 4 гэсэн үнэлгээ өгнө

№	Үнэлэх үзүүлэлт	Дүн				
		0	1	2	3	4
1	Үйлчлүүлэгч, гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	0	1	2	3	4
2	Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг	0	1	2	3	4
3	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	0	1	2	3	4
4	Өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэр гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	0	1	2	3	4
5	Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	0	1	2	3	4
6	Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт, бусад боломжийг алдалгүй ашигладаг	0	1	2	3	4
7	Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	0	1	2	3	4
8	Бусад эмнэлгийн эмч мэргэжилтэнтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
9	Эмнэлэг доторх эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
10	Ажиллаж байгаа эмнэлгийн доторх тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4
11	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4

1 эсвэл 4 оноо өгсөн бол шалтгаанаа бичнэ үү

- 1.
- 2.
- 3.

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... он сар

Суралцагч эмчийн нэр Үнэлэгчийн нэр

Сургалт эрхлэгч байгууллага: нэгж

Өвчтний нас эр эм

Өвчтөний зовиур: Шинж тэмдэг (signs and symptoms)

1. Хамар битүүрэх, 2. Хамраас нус гоожих 3. Нүүр чинэрч өвдөх 4. Толгой өвдөх
5. Халуурах 6. Хамраас залгиур руу нус урсаж орох 7. Хамрын хөндий хуурайших
8. Хамарт шархлаа үүсэх 9. Хамраас цус гарах 10. Найтаах 11. Хоолой хөндүүрлэх, 12. Хоолой хатах, хуурайших 13. Хоолой сэрвэгнэх 14. Дуу гунших 15. Хоолой сөөх 16. Амьсгал бачуурах 17. Чих хатгаж өвдөх 18. Чих загатнах 19. Чихнээс булаг гарах чих шуугих 20. Дүлийрэх

Сургалтын явцад суралцагч эмч ямар түвшинд байгааг өөрийн ажигласнаар дүгнэнэ үү				
№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
1	Өвчний өгүүлэмж авах			
2	Бодит үзлэг			
3	Оношилгоо эмчилгээний менежмент			
4	Харилцааны ур чадвар			
5	Эмнэл зүйн ерөнхий чадвар			
Сайн талууд		Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө		Бусад санал

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг

Суралцагчийн гарын үсэг

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд

Өвчний өгүүлэмж авах	Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Оношилгоо эмчилгээний менежмент	Зөв онош тавьдаг Оношилгоо эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг Тохирсон эмчилгээ эхлүүлдэг

	Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч хүнийг сайн сонсдог Тэдний зовинолыг хуваалцаж хүндэтгэлтэй ханддаг Тэдэнтэй эелдэг харилцаж, энгийн үг хэллэг хэрэглэн зөвлөгөө өгдөг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	Системтэй, харицан уялдаатай арга замыг сонгодог Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг. “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна.”

Гардан үйлдлийн үнэлгээ (DOPS)

Энэхүү гардан үйлдлийн үнэлгээ нь: эмнэлгийн нөхцөлд хийгддэг ажилбарыг ажиглах замаар үнэлж дүгнэдэг арга юм. Өвчтөний дэргэд эсвэл эмнэлзүйн дуураймал орчинд шалгуулагчийн техник ур чадварыг 15-25 минутын хугацаанд 9 онооны системээр үнэлдэг арга юм.

Үүнд:

- 1-3 оноо нь хангалтгүй
- 4-6 оноо нь хангалттай
- 7-9 оноо нь хангалттай маш сайн

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

..... он сар

Суралцагч эмчийн нэр Үнэлэгчийн нэр

Сургалт эрхлэх байгууллага: нэгж

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): Тасагт, амбулаторид, стандарт өвчтөн, бусад

Үйлчлүүлэгчийн нас, хүйс: эр/эм (доогуур нь зур)

Үзлэг (доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал (доогуур нь зур): хүнд, дунд, хөнгөн зэрэг

Гардан үйлдлийн нэр:

1. Хийж буй үйлдлийн техник болоод холбогдох ойлголтуудыг мэдэж буй

байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

2. Үйлчлүүлэгчээс холбогдох зөвшөөрлийг авсан эсэх

(ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

3. Гардан үйлдлийн өмнөх бэлтгэл ажил (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

4. Тайвшруулах ба сэтгэц нөлөөт эм бэлдмэлийг зөв сонгож, тун зөв эсэх, бэлтгэх (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
5. Техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
6. Халдваргүйжүүлэх техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
7. Зөв зохистой тусламж үйлчилгээг үзүүлэх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
8. Гардан үйлдлийн дараах менежмент (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
9. Харилцааны ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
10. Өвчтөнд тавьж буй анхаарал ба хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
11. Үйлдлийг гүйцэтгэх ерөнхий ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

Суралцагч эмч өнөөдрийг хүртэл хугацаанд тухайн гардан үйлдлийг хийсэн тоо
(.....)

№	Үнэлгээ	Хангалт гүй	Завсрын	Хангалт тай	Үнэлгээ өгөх боломжгүй
1	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг				
2	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг				
3	Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг				
4	Арга зүйг стандарт удирдамжийн дагуу чадварлаг гүйцэтгэдэг				
5	Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож шаардлагатай үед тусламж дууддаг.				
6	Үйлдлийн дараа багаж хэрэгслийг цэвэрлэдэг				
7	Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг				
8	Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Сайн тал:

Сайжруулах тал:

Бусад санал

Үнэлэгчийн гарын үсэг.....Суралцагчийн гарын үсэг

Ном зүй

1. “Эрчимт эмчилгээний үндэс” Г.Лхагважав нар англи хэлнээс орчуулсан 2009 он
2. “Эрчимтэй анагаахуйн үндэс, нэн хүнд өвчтөнийг аврах гарын авлага” Л.Ганболд нар англи хэлнээс орчуулсан, 2020 он.
3. “Эрчимт эмчилгээ” ном 4-р хэвлэл М.Наранпүрэв нар англи хэлнээс орчуулсан 2021 он.
4. Эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийн эмнэлзүйн хөтөч Л.Ганболд нар англи хэлнээс орчуулж эмхэтгэсэн, 2021 он.
5. E.Tintinalli “Emergency medicine” 7 th edition
6. John M. Field MD “Advanced cardiovascular life support”
7. John M. Field MD “PALS provider manual”
8. Justin Bowra “Emergency Ultrasound Made Easy”
9. Philip Wiest “Fundamentals of Emergency Radiology”
10. David Pescod нар “Мэдээгүйжүүлгийн сургалтын модулийн гарын авлага” 2010
11. “Орчны мэдээгүйжүүлэг” Г.Лхагважав англи хэлнээс орчуулсан 2006
12. “Физиология человека” Шмидт Р.Ф. ба Тюс Г. Англи хэлнээс орчуулсан, 2000
13. “Эмнэлгийн яаралтай тусламж” 4-р хэвлэл Г.Лхагважав нар англи хэлнээс орчуулсан 2010 он
14. “Хүний биеийн физиологи” Б.Отгон
15. Kaplan “Physiology lecture notes” Fourth edition
16. Joseph E. Parrillo, Phillip Dellinger “Critical care medicine: Principles of Diagnosis and Management in the Adult” 2018
17. John B. West, Andrew M. Luks “West’s Respiratory Physiology_ The Essentials” 2015
18. John B. West, Andrew M. Luks “West’s Pulmonary Pathophysiology” 2017